

ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА: ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН НӨЛӨӨ, ЖИН

Б.Санжмятав ¹

Даяаршлын эринд зах зээл нээгдэж, бараа, үйлчилгээний худалдаа чөлөөтэй болж, хүмүүсийн зорчих явдал эрс нэмэгдэв. Орчин үеийн тээвэр, харилцаа холбооны хөгжил нь орон зайг ойртуулж, цаг хугацааг товчлох болсон нь хөгжлийг ихэд хурдасгав. Улс орнуудын эдийн засаг улам бүр харилцан хамааралтай, нэгдмэл болж, бие биеэ нөхөх чиглэлээр хөгжиж байгаа тул гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, орчин үеийн техник, технологийн ололтоос авч ашиглах өргөн бололцоо нээгдсэн. Даяаршилаас хамгийн илүү хожсон бүлэг гэвэл хөгжиж буй орнууд болно.

Дэлхийн эдийн засаг өргөжин хөгжихийн хирээр хөгжиж буй орнуудын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн, юуны өмнө түүхий эд, эрчим хүчний эх үүсвэрийн хэрэглээ эрс нэмэгдэж, үнэ богино хугацаанд хэд дахин өссөн. Экспортоос орох орлого нэмэгдэж, хөгжлийн санхүүжилт өссөнөөр эдийн засгийн идэвх сайжирч, ард түмнийх нь амьдралын түвшин дээшилж ирсэн байна.

Олон улсын валютын сангаас 2007 оны эцсээр гаргасан судалгаагаар, дэлхийн улсуудын ДНБ-ийг худалдан авах чадвараар нь тооцоход, хамгийн том 12 эдийн засагт өрнөдийн үйлдвэржсөн зөвхөн 4 орон -АНУ, Япон, Герман, Франц, хөгжиж буй орнуудаас 8 орон: БНХАУ, Энэтхэг, ОХУ, Бразил, Мексик, БНСолонгос, Индонези, Турк улсууд орсон байна. Ийнхүү дэлхийн эдийн засагт хөгжиж буй орнуудын нөлөө, жин нэмэгдэх хандлага цаашид ч үргэлжлэх болно.

АНУ-ын Үндэсний судалгааны зөвлөлөөс 2008 оны 11 дүгээр сард гаргасан “Дэлхийн хөгжлийн төлөв, 2025”² судалгаанд дурдаснаар, Хятад, Бразил, Энэтхэг, ОХУ-ын ДНБ-ний хэмжээ нь 2040-2050 онд одоогийн их долоог гүйцнэ. Хятад ДНБ-нийхээ хэмжээгээр 2008 онд Их Британийг, 2010 онд Германыг, 2015 онд Японыг, 2035 онд АНУ-ыг гүйцэх бол, Энэтхэг 2014 онд Италийг, 2016 онд Францыг, 2021 онд Германыг, 2026 онд Японыг тус тус гүйцэж түрүүлнэ³. Америкийн эрдэмтдээс 2010 онд гаргасан судалгаагаар, олон улсын мөнгө санхүүгийн хямралаас шалтгаалан Хятад АНУ-ыг 2025 он гэхэд гүйцэх ажээ.⁴ 2025 онд дэлхийн хамгийн том 8 эдийн засаг бол – АНУ, Хятад, Энэтхэг, Япон, Герман, Англи, Франц ба ОХУ байх ажээ. Хэрвээ Хятад, Энэтхэг, ОХУ нь бодлогын томоохон асуудлуудаар нэгдвэл дэлхийн бодлогод шийдвэрлэх

¹ МУИС-ийн ОУХС-ийн докторант

² *Global trends, 2025*, www.nic.org

³ *Goldman Sachs, Global Economics Paper N 99, October 2003*

⁴ *Yves Tiberghien, What does China expect from Global Economic and Environment Governance? Stanford University, 3.10.2010.*

нөлөөтэй болно. Тэдгээрийн дараа Индонези, Иран, Турк орж, улам нөлөөтэй болж байна.

Европ, Хойд Америкийн зүгээс дэлхийн эдийн засаг, банк, санхүү, техник, технологи, соёл, мэдээллийн салбарт дангаар ноёрхож байсан байдал аажмаар бүдгэрч, байхгүй болж байна. Тухайлбал, өнөөдөр Хятад нь валютын нөөц, экспортынхоо хэмжээгээрээ дэлхийд 1 дүгээрт, Бразил хөдөө аж ахуйн бизнес, биотүлшний салбарт, ОХУ эрчим хүч, металлын салбарт, Энэтхэг мэдээллийн технологи, эм хангамж, автомашины эд анги, мэдээллийн салбарын үйлчилгээний экспортоор, Хятад ган, гэрийн хэрэглээний хэрэгсэл, цахилгаан холбооны тоног төхөөрөмжийн салбарт тус тус тэргүүлэх болов. Харин АНУ-ын шинжлэх ухаан, шинэчлэл, цэргийн салбар дахь давуу байдал нэлээд хугацаанд хадгалагдаж үлдэх төлөвтэй.

Дэлхийн хүн амын ихэнх нь хөгжиж буй орнуудад амьдарч, цаашдаа ч өсөх хандлагатай байхад өрнөдийн орнуудын, юуны өмнө Европ, Японы хүн амын тоо нэмэгдэхгүй буюу хөгшрөх төлөвтэй байна. Дэлхийн хүн ам 2050 онд 9 тэрбум болох ба тэдний 86% нь хөгжиж буй болон шинээр эрчимтэй хөгжиж буй орнуудад, түүний хагас нь Хятад, Энэтхэгт амьдрахаар байна. Гэтэл өрнөдийн үйлдвэржсэн баян орнууд болох АНУ, Европ, Японы хүн ам нь дэлхийн хүн амын дөнгөж 9% болох ажээ.

Сүүлийн хэдэн жилд хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн 80%-ийг дангаараа хангаж байна. ОУВС-аас хийсэн судалгаагаар дэлхийн эдийн засаг 2009 онд 0,5%-иар буурсан бол 2010 онд өсөлт гарахаар байна. Өндөр хөгжсөн өрнөдийн орнуудын эдийн засаг 2,25%-иар өсөх, түүний дотор АНУ-ын эдийн засгийн өсөлт Европ, Японыхоос илүү өндөр байх, хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт 6,25% байх төлөвтэй⁵.

Дэлхийн мөнгө санхүү, эдийн засгийн төв Ази руу аажмаар шилжиж байгааг дараах хүснэгтээс харж болох юм⁶:

	Хүн ам тэрбум 2005 2020		ДНБ Тэрбум \$ 2005	ДНБ ¹ Тэрбум \$ 2020	Жилийн өсөлт %	1 хүнд ног-дох ДНБ, \$
Ази	3,1	3,5	9783	32 120	4,1	5074
Европ	0,45	0,47	13568	18 011	2,3	40619
АНУ	0,29	0,33	12376	19 904	3,2	60097
Дэлхий	6,12	7,46	44309	93 057	3,6	10051

БНХАУ л гэхэд сүүлийн 30 жилд тасралтгүй жилд дунджаар 9.7%-иар өсч ДНБ-ийг худалдан авах чадвараар нь тооцож үзснээр дэлхийн нийт ДНБ-ний 10%-ийг эзлэж байгаа ба 2020 онд 15% болох, Энэтхэг 1991 оноос хойш жилд дунджаар 6,3%-иар өсч, одоо дэлхийн нийт ДНБ-ий 5%-ийг бүрэлдүүлж, 2020 онд 10% болохоор байна.

Шинээр эрчимтэй хөгжиж буй орнуудын эдийн засаг, нийгмийн салбарт олсон амжилт, менежмент нь дэлхийн бусад орнуудын анхаарлыг зүй ёсоор татаж, одоо төрийн удирдлагатай зах зээлийн эдийн засгийн загвар улам бүр сонирхол татах болов.

Сүүлийн 20 жилд дэлхийн хэмжээнд түүхий эд, эрчим хүчний эх үүсвэрийн хэрэглээ нэмэгдэж, үнэ өссөний дүнд хөгжиж буй орнуудын худалдаа, төлбөрийн баланс ашигтай байж, ихээхэн хэмжээний мөнгө хуримтлуулж чадсан нь өнөөгийн олон улсын санхүү, эдийн засгийн хямралын үед томоохон хөзөр болж байна. Өрнөдийн орнууд эдийн засгаа хямралаас аварч, идэвхийг нь сэргээхийн тулд томоохон хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

⁵ World Economic outlook, 2010 www.imf.org

⁶ Emerging Asian Regionalism, www.adb.org

Гэвч тэдэнд дээрх хөтөлбөрөө хэрэгжүүлэх хөрөнгө, мөнгө байхгүй болно. Энэ нөхцөлд Хятад, Энэтхэг, ОХУ, Персийн булангийн орнууд дутагдаж байгаа мөнгийг нь гаргаж байна. Эдийн засагчдын судалгаанаас үзвэл 2009 онд л гэхэд Европын орнуудын засгийн газраас 7 хоног тутамд 20 тэрбум еврогийн засгийн газрын үнэт цаасыг гарган зах зээл дээр борлуулж байжээ. Ийнхүү үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орнууд нь дэлхийн санхүүгийн зах зээл дээр санхүүжүүлэгч байхаа больж, харин зээлдэгч болж хувирсан. Олон улсын мөнгө санхүүгийн хямралын явцад хөгжиж буй орны засгийн газар, биеэ даасан сан, компанийн зүгээс хувьцааных нь үнэ хагас илүүгээр унасан өрнөдийн томоохон банк, компанийн хувьцаанаас нэлээд хэмжээгээр хямд худалдан авсан нь баялгийн дахин хуваарилалт болж буйн бас нэг жишээ болно.

Эрчимтэй хөгжиж буй орнууд бүс нутгийн хөгжлийн банк, биеэ даасан сангуудыг олноор нь байгуулав. Тэдгээрийн хөрөнгө мөнгө нь ОУВС, Дэлхийн банкны зээл олгох хөрөнгийн хэмжээнээс хавьгүй давжээ. Тухайлбал, ОУВС-гаас зээл олгоход зориулсан нийт хөрөнгийн хэмжээ нь 250 тэрбум ам. доллар байгаа бол, биеэ даасан сангуудын хөрөнгийн хэмжээ 3 865 тэрбум ам.доллар⁷ болжээ. Эдгээр сангууд нь үндсэндээ хөгжиж буй орнуудынх байна. Хөгжиж буй орнууд өөр хоорондын хамтын ажиллагаанд улс төрийн нөхцөлгүй, илүү шударга нөхцлөөр зээл олгож, эдийн засаг, санхүүгийн туслалцааг харилцан үзүүлж эхлээд байна.

Эдгээрээс үндэслэн ХХ зуунд тогтсон олон улсын харилцааны улс төр, мөнгө санхүү, худалдаа, эдийн засгийн системийг бүхлээр нь шинэ нөхцөл байдалд тохируулан өөрчлөх асуудал тавигдаж байна.

Олон улсын улс төрийн өнөөгийн систем нь дэлхийн хоёрдугаар дайны дараа бүрэлдэн бий болсон. Дэлхийн хувь заяаг тодорхойлох, хүн төрөлхөтнийг энх амгалан амьдруулах зорилготой дээрх систем бүрэлдэхэд дайнд ялагч болсон гүрнүүд тэр үед бий болсон өөрсдийн давамгайл байдлаа баталгаажуулж авсан байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) 1945 оны 10 дугаар сарын 24-нд байгуулагдахад 51 гишүүнтэй байсан. Гэтэл өнөөдөр НҮБ-ын гишүүдийн тоо нь 192 болж бараг 4 дахин өсчээ. Түүнээс гадна олон хөгжиж буй улс орон эрчимтэй хөгжиж тэдгээрийн улс төр, цэрэг, эдийн засгийн нөлөө нь нэмэгдсний дүнд дэлхийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрсэн ба цэрэг дайны болон хөгжлийн олон асуудлыг тэдний оролцоогүйгээр шийдвэрлэх бололцоогүй болсон байна. НҮБ-ын өмнө тавигддаг хамгийн чухал асуудлууд, түүний дотор дайн, энхийн асуудлыг хэлэлцэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг хамгийн чухал байгууллага болох Аюулгүйн Зөвлөл (АЗ)-д тухайн үед дэлхийн 2 дугаар дайнд ялагч болсон томоохон орнууд болох - АНУ, ОХУ, Хятад, Франц, Англи улсууд байнгын гишүүн болж, АЗ-өөс гаргах аливаа шийдвэрт хориг тавих эрх эдлэх болсон юм. Тухайн үедээ дайнд ялагдагч болсон томоохон орнууд болох Герман, Япон АЗ-д суудал эзэлж чадаагүй. Гэтэл дэлхийн хүн амын 1/6 буюу 1 тэрбум гаруй хүн амтай, дэлхийн 4 дэх эдийн засаг болох Энэтхэг улс, 50 гаруй орноос бүрдсэн Африк тив, эрчимтэй хөгжиж буй Латин Америк нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд байнгын гишүүний төлөөлөлгүй байна.

НҮБ нь дайн энхийн тулгамдсан асуудлаас бусад асуудлаар зөвлөмжийн чанартай шийдвэр гаргадгаас, мөн Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүд нь сүүлийн жилүүдэд хориг тавих эрхээ улс төрийн зорилгоор нэлээд хэрэглэх болсноор НҮБ-аас тухайн цаг үед шаардлагатай шийдвэр гарах үйл явц нь удааширч, нийт системийн үйл ажиллагааны үр өгөөжийг бууруулж эхэлсэн. Тийм учраас НҮБ түүний системийн байгууллагуудын шийдвэр гаргах дээрх системд өөрчлөлт

⁷ *Fonds souverains et crise des surprimes. Diplomatie 34, 2008,*

оруулахгүйгээр, нэгэнт гаргасан шийдвэрийг хүчлэн биелүүлдэг болгохгүйгээр тэдгээрийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах бололцоогүй болжээ. Дэлхийн худалдааны байгууллага нь НҮБ-ын системийн байгууллагуудад энэ талаар үлгэр болж чадах юм. Учир нь ДХБ-ын шийдвэрийг гишүүн улсууд нь заавал биелүүлэх үүрэгтэй ба хэрвээ аливаа нэгэн гишүүн орон тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхгүй бол Маргаан шийдвэрлэх байгууллагаараа дамжуулан заавал биелүүлэх арга хэмжээг авдаг журамтай.

НҮБ-ын системийн хамгийн нөлөө бүхий төрөлжсөн байгууллагууд бол ОУВС, ДБ болно. 1944 оны 7 дугаар сард байгуулагдсан ОУВС-ийн гол зорилго бол “мөнгөний олон улсын системийг тогтвортой байлгах, үүсч болох мөнгө, санхүүгийн хямралыг зохицуулах үүрэгтэй”, эгнээндээ 186 орныг нэгтгэсэн. ДБ нь эдийн засгийг сэргээн босгох, хөгжлийн зээлийг гишүүн орнуудад олгож туслах зорилготой бөгөөд эгнээндээ 187 орныг нэгтгэдэг байна. Эдгээр байгууллагад ч НҮБ-ын нэгэн адил дэлхийн хоёрдугаар дайнд ялагч болсон орнуудын нөлөө илт давамгайлсан, тэгш бус систем хэвээр байгаа билээ. Тухайлбал гишүүн орнуудаас ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээгээр саналыг хуваарилсан тул АНУ нийт саналын 16,79%, ЕХ 32,2%-ийн саналыг эзэмшиж байгаа нь нийт саналын 48,99%⁸ болж байгаа тул тэдгээр орнууд (27+1 орон) ОУВС, ДБ-нд өөрийн бодлогоо хэрэгжүүлэх бүрэн бололцоогоор хангагдсан, ОУВС-д шийдвэр гаргах журмын дагуу АНУ нь ганцаараа аливаа шийдвэрт хориг тавих эрхтэй байхад, бусад гишүүд нь тийм бололцоогүй үлджээ. Ингээд ОУВС-гийн захирлаар европын төлөөлөгчийг, ДБ-ны Ерөнхийлөгчөөр америкийн төлөөлөгчийг сонгодог уламжлал тогтжээ.

2005 онд Нью-Йоркод болсон дэлхийн дээд хэмжээний уулзалтаас НҮБ-ын үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах, үр ашгийг нь дээшлүүлэх асуудлаар илтгэл, санал боловсруулан танилцуулах үүргийг НБДНГ-т өгчээ. Энэ ажлын хүрээнд НБДНГ-аас боловсруулсан анхны томоохон илтгэл болох “Дэлхий дахинд байгууллагын үүрэг ролийг нэмэгдүүлэх арга замууд” гэсэн илтгэлийг 2006 онд болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд танилцуулсан, одоо ч байнга яригдаж байна.

Хөгжиж буй орнууд ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээгээр санал өгдөг хуучин зарчмыг өөрчлөх талаар зарчмын амлалтыг авсан ба 2007 онд шинээр эрчимтэй хөгжиж буй зарим орны саналын эрхийг, 2008 онд бусад 50 гаруй орны саналын эрхийг бага ч болов нэмэгдүүлэх завсрын шийдвэрийг тус тус гаргуулж чадсан байна.

Дэлхийн худалдааны байгууллагад аливаа асуудлыг консенсусаар буюу нийтийн тохиролцоогоор шийдвэрлэх тул энд хөгжиж буй орнууд асуудлыг шийдвэрлэх нөлөөтэй оролцдог. ДХБ-ын хүрээнд гаргах шийдвэрийн төслийн талаар Их 4-ийн бүлэг буюу АНУ, ЕХ (өрнөдийн орнуудыг төлөөлж), Бразил, Энэтхэг (хөгжиж буй орнуудыг төлөөлж) гэсэн 4 орны төлөөллөөс бүрдсэн G4-өөр урьдчилан ярьдаг болжээ. Мөн хөгжиж буй орнууд G90-ийн хүрээнд өөрийн байр сууриа тодорхойлон гаргаж байна.

Даяаршлын үед улс орнууд ялангуяа томоохон орнууд хамтарч шийдвэрлэхээс аргагүй асуудлууд олон болжээ. Тэдгээрийн тоонд дэлхийн банк санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах, цаг агаарын дулааралтай тэмцэх, эрчим хүч, хоол хүнсний найдвартай хангамжийг бий болгох, олон улсын терроризмтай тэмцэх, цагаачлагчдыг байршуулах зэрэг олон асуудал орж байна. Эдгээр асуудлуудыг дэлхийн хэмжээнд авч үзэж, хамтын чармайлтаар шийдвэрлэх, бүр багцаар нь авч шийдвэрлэхээс өөр арга зам байхгүй байна.

⁸ www.imf.org
www.wb.org

Дэлхийн хэмжээнд тогтсон системүүдийг өөрчлөхөд хугацаа шаардагдах учраас асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхийн тулд олон талт хамтын ажиллагааны завсрын механизмуудыг ч бий болгосон. Тэдгээрийн хүрээнд дэлхийн тулгамдсан асуудлуудыг авч ярилцан албан бус боловч зарчмын шийдвэрүүдийг гаргаж, түүнийгээ холбогдох түвшинд албан ёсны болгохыг зорьж ажилладаг болно. Тэдгээрийн түгээмэл жишээ бол дэлхийн бодлогод нөлөө бүхий орнуудын удирдагчдын, тухайлбал G7, G8-ын уулзалтыг өргөжүүлэх замаар Хятад, Энэтхэг, Бразил, Мексик, ӨАБНУ-ыг оруулан G13-ын бүлгийн хэлбэрээр ажиллах болсон ба 2009 онд түүнд Египетийг нэмж оруулан G14-ийн хэлбэрт оржээ.

Олон улсын мөнгө санхүү, эдийн засгийн хямрал нь дэлхийн хэмжээнд ямар нэгэн нэгдсэн зохицуулалттай байхыг шаардаж байгаа тул 1999 онд үндэс суурь нь тавигдсан хамгийн том эдийн засагтай 20 орныг нэгтгэсэн Их 20-ын бүлгийг 2007 онд байгуулсан. Их 20-ын бүлэг нь дэлхийг илүү төлөөлөх чадвартай механизм болсон байна:

Дэлхийн хамгийн том 20 эдийн засагтай улсууд⁹

	Дэлхийн хүн амд эзлэх жин	Дэлхийн ДНБ-д эзлэх жин
АНУ	4,6	20.8
ЕХ	6,9	22.3
Япон	2,1	6,4
Хятад	19,9	11,4
Энэтхэг	17,1	4,7
Герман	1,2	4,2
Англи	0,9	3,2
ОХУ	2,1	3,2
Франц	0,9	3,1
Бразил	2,9	2,8
Итали	0,9	2,6
Мексик	1,6	2,0
Канад	0,5	1,9
БНСУ	0,7	1,8
Индонези	3,5	1,3
Турк	1,1	1,3
Австрали	0,3	1,2
Аргентин	0,6	0,8
Саудын Араб	0,4	0,8
ӨАБНУ	0,7	0,7
Бүгд	69.8	96.5

Ийнхүү дэлхийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудын үүрэг роль жилээс жилд өсч байна. Хөгжиж буй орнууд нь өөр хоорондынхоо хамтын ажиллагааг өргөжүүлж, G77+Хятад, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, G4 (Хятад, Энэтхэг, ОХУ, Бразил), G5 (Хятад, Энэтхэг, ӨАБНУ, Бразил, Мексик), G90 (нийт хөгжиж буй орнууд) бүлгийн хэмжээнд бодлогынхоо зохицуулалтыг хийж байгаа болно. Мөн сүүлийн жилүүдэд Хятад+Африк, Энэтхэг+Африкийн клубууд ч байгуулагдав. Тэдний өөр хоорондын хамтын ажиллагааг дэмжих зорилготой сангууд байгуулагдсан.

Их 20-ын бүлгийн дээд хэмжээний анхны уулзалт 2007 оны 12 дугаар сард Вашингтонд болж, бүлгийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлсэн байна. Их 20-ын бүлгийн Вашингтон,

⁹ Le Figaro, 01.04.2009

Лондон, Сөүлийн уулзалтууд нь олон улсын мөнгө санхүү, эдийн засгийн хямралаас гаргах арга хэмжээний талаар ярилцаж зарим тодорхой шийдвэрүүдийг гаргасан нь чухал ач холбогдолтой болжээ.

Ийнхүү хөгжиж буй орнууд, юуны өмнө эрчимтэй хөгжиж буй орнууд өөрсдийн зүгээс дэлхийн эдийн засагт эзлэх байр суурьтайгаа тэнцэх хэмжээний байр суурийг олон улсын хэмжээнд баталгаажуулах бодлого явуулж, тодорхой үр дүнд хүрч байна. Эдгээрийн үр дүнд дэлхийн бодлогын төв Америк, Европоос Ази руу аажмаар шилжиж эхэлсэн нь XXI зууны онцлог болов.